Үндсэн хөрөнгөнд урсгал төсвөөс 26,503.7 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй 323,098.7 мянган төгрөгийн нийт 352,292.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу 744,835.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 193,116.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Тайлант онд 2,220.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын татварын өглөг үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,272,877.2 мянган төгрөг болж 715,247.8 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газрын тогтоолоор үндсэн хөрөнгө хувьчилсан, нэмэлт санхүүжилтийн төслийн санхүүжилтийн авлага олгосныг тайлант онд зарцуулсан зэргээс шалтгаалжээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,135,988.1 мянган төгрөгөөр буюу 46.1 хувиар өссөн байна. Энэ нь нэмэлт санхүүжилтээр Хятадын ард түмэнд найрсаг хөршийн хувиар сэтгэлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 30 мянган хонь бэлтгэхэд Засгийн газрын нөөцөөс болон Эрдэнэс Тавантолгой ХК-аас олгосон хандив тусламжийн орлогыг төвлөрүүлж зарцуулсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 4,813,004.9 мянган төгрөгөөр буюу 82.2 хувиар өссөн байна. Энэ нь дээрх 30 мянган хонь бэлтгэхэд 3,925,765.9 мянган төгрөгийг зарцуулж, Засгийн газрын 2020 оны 75 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 983,379.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн үр дүнг 67,000.0 мянган төгрөгөөр бууруулсан нь Засгийн газрын тогтоолын дагуу хувьчилж, данснаас хассан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг бууруулсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 4,030.471.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн нийт зарлагыг 832,851.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 4,863,322.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2020 оны 9 дүгээр сард тодотгол хийн дахин 335,949.4 мянган төгрөгөөр нэмсэн байна.

Төсвийн төслөөс нийт зарлагыг 1,168,800.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд дараах зардлуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын тогтоолоор цалингийн сүлжээ шинэчлэн батлагдсантай холбоотойгоор цалин, нийгмийн даатгалын зардал 598,425.0 мянга;
- Салбарын Олон улсын байгууллагуудын гишүүнчлэлийн төлбөр нэмэгдсэнээс Гадаад шилжүүлгийн зардал 345,255.5 мянга;
- Засгийн газрын тогтоолоор улсын сайн малчин, тариаланчийн тоо нэмж батлагдсантай холбоотойгоор Сайн малчин, тариаланчдын шагналын зардлыг 167,000.0 мянга;
- Багаж техник хэрэгсэл авах зардлыг 45,547.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага” хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,199,272.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 5,190,804.9 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 8,467.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,189,863.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 5,938.0 мянган төгрөг төвлөрч, нийт 5,195,801.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,092,920.2 мянган төгрөгийг зарцуулж 102,881.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны буюу цайны газрын түрээсийн орлого 2,529.2 мянган төгрөгөөр тасарсан нь Короновируст цар тахлын улмаас түрээслэгч компанийн үйл ажиллагаа зогссоноос шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,092,920.2 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 40,917.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 35,459.4 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 10,667.7 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 9,552.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 3,030,656.8 мянган төгрөг, өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа гадаад төсөл хөтөлбөрөөс 265,412.0 мянга, Засгийн газрын нөөц сангаас 1,474,519.9 мянга, бусад орлогоос 167.2 мянга, нийт 4,770,755.9 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлжээ.

Үүнээс Хятадын ард түмэнд найрсаг хөршийн хувиар сэтгэлийн дэмжлэг үзүүлж, 30 мянган хонь бэлтгэж, хүлээлгэн өгөх арга хэмжээнд 3,926,515.9 мянган төгрөгийг, мөн аяны хүрээнд 2018 онд төвлөрсөн 177,716.8 мянган төгрөгийн хандивыг шилжүүлсэн бөгөөд Улсын аварга малчин өрх, улсын хошой малчин өрх, улсын аварга тариаланч хамт олон, аварга тариаланчийн шагналд 400,944.0 мянган төгрөгийг, өмнөх оноос дамжин хэрэгжиж буй 3 төсөл хөтөлбөрт 122,453.2 мянган төгрөгийг нийт 4,627,629.9 мянган төгрөгийг зарцуулан, үлдэгдэл 143,126.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 20 төрлийн 149 мэдээлэл оруулахаас 120 мэдээллийг хугацаанд нь бүрэн, 10 мэдээллийг дутуу, 19 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Дараах 10 мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу мэдээлээгүй байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн шууд захирагчийн түвшинд төлөвлөж, батлуулаагүй тул тус яамны төсвөөс худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй,
- Төсвийн шууд захирагчийн төсөвт болон нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн 11 удаагийн 3,782,959.2 мянган төгрөгийн худалдан авалтын тендерийн ерөнхий мэдээллийг байршуулаагүй,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6 удаагийн 400,878.9 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 байгууллагаас худалдан авсан 306,934.7 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэргийг мэдээлээгүй,
- Эхний хагас жилд БНХАУ-д хүмүүнлэгийн хандив, тусламж олгосныг мэдээлээгүй,
- Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны 50 дугаар тогтоолоор тус яамны орон тооны хязгаарт өөрчлөлт орсныг мэдээлээгүй, өмнөх саруудад зөрүүтэй мэдээлэл тавьсан,
- Тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсныг мэдээлээгүй,
- Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг сүүлийн 3 сард мэдээлээгүй, зарим сард дутуу мэдээлсэн,
- Тус яамны төсөвт хамааралгүй хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн хэсэгт төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээллийг, дутуу ойлгомжгүй байдлаар оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 34,504.0 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 157,872.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 33,589.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 42,538.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 81,743.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Гражийн газрын дахин үнэлгээний 2,689.8 мянган төгрөгийн нэмэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэснийг Засгийн газрын оруулсан капитал дансанд,
2. Бусад байгууллагад шилжүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаар бүртгэснийг үйл ажиллагааны бус зардалд,

3. Гэрээний дагуу 10,900.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж шууд зардлаар бүртгэснийг Урьдчилж төлсөн зардал/төлбөрийн дансанд тус тус залруулга хийлгэлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 124,282.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 42,538.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант оны нийт 42,538.9 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулаагүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэж заасныг болон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-д заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Шилэн дансны нэгдсэн системд нийт 10 мэдээллийг дутуу болон зөрүүтэй, 19 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “Шилэн дансны зарчим 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.6, 6.3.5, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 6.4.5, 6.4.7-д заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 81,743.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд ажиглагдаа. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 25 дугаар захирамжаар Ерөнхийлөгчөөс Коронавируст халдвар, цар тахалтай тэмцэж буй Хятадын ард түмэнд найрсаг хөршийн хувиар сэтгэлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор БНХАУ-д хийсэн айчлалын үеэр Монголын ард түмнийг төлөөлөн хандивласан 30 мянган хонийг хүлээлгэн өгөх ажлын хэсэг байгуулсан байна. Тус ажлын хэсгийн даргаар ХХААХҮС-ыг томилж, ажлын дэд хэсэг байгуулж хонь худалдан авах тендерийг зохион байгуулахаар даалгасны дагуу ХХААХҮЯ-ны нэмэлт санхүүжилтийн дансаар Засгийн газрын нөөц сангаас 1,076.0 сая төгрөгийн, Эрдэнэс-Тавантолгой ХК-аас 1.0 сая ам доллар буюу 2,852.9 сая төгрөгийн хандивын орлого төвлөрүүлэн зарцуулсан байна.

Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

- Албан тушаалын болон албан ажлын суудлын авто машин хэрэглэх эрх бүхий 3 албан тушаалтан болон нийтлэг үйлчилгээний зориулалтаар ашиглагддаг нийт 9 авто машин байгаагаас 5 авто машины цилиндрийн хэмжээ 2500 см.кубээс их буюу 3956-аас 5663 см.кубын эзэлхүүнтэй байна.

Албан тушаалын болон албан ажлын суудлын авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү цилиндрийн багтаамжтай авто машин хэрэглэж байгаа нь тус тогтоолын хэрэгжилт хангагдаагүй, төсөв хэмнэгдэх боломж алдагдаж байгаа тул уг асуудлыг дараагийн аудитаар нэгтгэн авч үзэх нь ач холбогдолтой байна.

- Урсгал болон нэмэлт санхүүжилтээс худалдан авсан бараа ажил үйлчилгээний тендер худалдан авалтыг цахим системээр зохион байгуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Захиалагч урилгыг энэ хуулийн 52.1, 12-т заасан цахим хуудсан байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ” гэж заасантай нийцээгүй тул дараагийн аудитаар авч үзэн, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлнэ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орон тооны хязгаар болон цалингийн зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны орон тооны хязгаарт батлагдаагүй 14 үйлчилгээний ажилтны цалин, хөлсийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд төлөвлөн батлуулж 202,502.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоолын хавсралтын 11-д "орон тооны хязгаар 113", 2020 оны 50 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны орон тооны хязгаарыг 105 байхаар тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн төлөвлөлтийг батлагдсан тогтоол шийдвэрийн дагуу бодитой тооцож төлөвлөөгүй байх, тогтоол шийдвэргүйгээр төсвийн хөрөнгө зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаагүй үйлчилгээний ажилчдын орон тооны асуудлыг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын орон тооны хязгаар баталсан тогтоолд нийцүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2.Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төсөвт тусгаагүй эмнэлгийн зориулалттай 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг урсгал зардлаас бэлтгэж, шилжүүлсэн, 8,271.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1-д "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8/-д "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"- тай тус тус нийцээгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсөвт тусгагдаагүй хөрөнгө бэлтгэх, холбогдох хууль, журам зөрчигдөх, холбогдох хууль, журам зөрчигдөх, төсвийг дотоод хяналтгүй, зориулалт бусаар зарцуулах;

2.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зохих зөвшөөрлийн дагуу хөрөнгө бэлтгэн шилжүүлж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.Хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Албан тушаалын болон албан ажлын суудлын авто машин хэрэглэх эрх бүхий 3 албан тушаалтны ашиглаж байгаа автомашин нь тус яамны хөрөнгөнд бүртгэлгүй, харьяа болон байгууллагуудын эзэмшилд бүртгэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Төрийн байгууллага, албан газар ... нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 13 (а)-д "Үндсэн хөрөнгө гэдэг нь ...түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа..." гэж тодорхойлсон заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт үр ашиггүй байх, эзэнгүйдэх, хөрөнгийн засвар, үйлчилгээ, татвар төлбөр хураамжийн зардал гарч, төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагаандаа ашигладаг автомашины эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд 2,220.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, мөн жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

4.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан дахь авлага, өр төлбөрийн дансдыг үнэн зөв тайлагнагдсан эсэхийг баталгаажуулах боломжгүй болох, санхүүгийн тайлан материаллаг хэмжээний зөрчилтэй илэрхийлэгдэх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зүй зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх, санхүүгийн тайлан гаргахын өмнөх харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж акт үйлдэж байх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

5. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 47,138.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

5.2. Эрсдэл:

Тухайн ажил гүйлгээ, тооцоолол үнэн зөв хийгдээгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах.

5.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж бүртгэл тайланд тусгаж байх;

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

"Төрийн алба хаасан хугацаа тогтоосон баримтыг нөхөн гаргаж өгсөн" гэсэн тайлбарыг ирүүлсэн боловч 1 хүнд тэтгэмж бодож олгосон баримтыг бүрэн ирүүлсэн гэж үзэн зөрчлийн дүнгээс хасаж тооцсон болно.

6. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Үндсэн цалин, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт, урамшууллыг бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнаагүй байна. Тухайлбал тайлант онд 204,559.5 мянган төгрөгийн урамшуулал бодож олгосныг үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлаар, унаа хоолны хөнгөлөлтийг бодит гүйцэтгэлээс 19,881.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байдлаар тус тус тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн дансны зааврын 3.6-ийн а-д "Тайлангийн хугацаанд олговол зохих цалинг: Дт.Цалингийн зардал Кт.Цалингийн тооцоо", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар" зэрэг зүйл заалттай нийцээгүй.

6.2. Эрсдэл:

Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зардлын гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, цалингийн зардалтай холбоотой үүссэн ажил гүйлгээ орхигдох, мэдээлэл хэрэглэгчдэд зөрүүтэй мэдээлэл хүрэх.

6.3. Өгсөн зөвлөмж:

Цалингийн зардлын бүртгэлийг бодит гүйцэтгэл, баримтыг үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн дансны зааврын 3.6-д заасны дагуу бүртгэж, тайлагнаж байх.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			САГ-2020/116/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангаж ажиллаагүй, тайлант онд нийт 10 төрлийн мэдээллийг дутуу болон зөрүүтэй, 19 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.		Албан шаардлага өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
2	Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөөгүй.	42,538.9	Албан шаардлага өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
3	Тус яамны орон тоонд батлагдаагүй ч цалингийн зардал нь батлагдсан 14 үйлчилгээний ажилтан ажиллаж байна.		Зөвлөмж хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
4	Төсөвт тусгагдаж батлагдаагүй хөрөнгө бэлтгэж шилжүүлсэн, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулж гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй.	32,384.6	Зөвлөмж хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
5	Тус яамны санхүүгийн тайланд бүртгэлгүй харьяа байгууллагуудын эзэмшлийн 3 авто машиныг ашиглаж байна.		Зөвлөмж хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
6	Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс өглөг үүсгэсэн, мөн жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	2,220.5	Зөвлөмж хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
7	Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан.	47,138.6	Зөвлөмж хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
8	Цалингийн зардлыг сар бүр бодит гүйцэтгэлд үндэслэн бүртгээгүй, үндсэн, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт, урамшууллыг батлагдсан зардлын дансдын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнаагүй байна.		Зөвлөмж хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Т.Даваажаргал
ДҮН		124,282.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 37/АД160063

Улаанбаатар хот

С.А.Г. 2021/116/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд нийт 42,538.9 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтад харьцуулалтын тендер зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасныг болон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг тус тус мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулаагүй зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, нягтлан бодогч Т.Даваажаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 38/АС160063

Улаанбаатар хот

СНТ- 2021/116/СТН-ПМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 149 мэдээлэл байршуулахаас 10 төрлийн мэдээллийг дутуу болон зөрүүтэй мэдээлж, 19 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.6, 6.3.5, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 6.4.5, 6.4.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-д "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу болон зөрүүтэй мэдээлэх, хугацаа хоцроох, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан гаргаагүй зэрэг зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, нягтлан бодогч Т.Даваажаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.Эрдэнэзул

Б.ЭРДЭНЭЗУЛ

[illegible]